

## Эхлэл

<sup>1</sup>-р бүлэг.<sup>1</sup> Орчлон өртөнцийг анх Ертөнцийн Эзэн бүтээжээ.<sup>2</sup> Тэр үед энэ дэлхий хэлбэр дүрсээ ч олоогүй, эль хуль хоосон байсан юм. Эргэн тойронд зөвхөн гүн харанхуй нöёрхож, гүнзгий ус цалгин, Ертөнцийн Эзэний хүчит сүнс л тэрхүү түнэр харанхуйд, хөлгүй их усан дээгүүр аялан байв.

<sup>3</sup>Тэгээд Ертөнцийн Эзэн,

— Гэрэл гэгээ бий болсугай гэнгүүт гэрэл үүслээ.<sup>4</sup> Ертөнцийн Эзэн гэрэл хир зэрэг сайхан болохыг хараад, улмаар орчлонгийн гэрэлтэй хэсгийг харанхуйгаас тусгаарлан <sup>5</sup>гэрлийг «өдөр», харанхуйг «шөнө» хэмээн нэрлэв. Ингээд шөнө болж улмаар өглөө эхлэн нэгдэх өдөр өнгөрөв.

<sup>6</sup>Хоёрдахь өдрөө Ертөнцийн Эзэн,

— Хөлгүй их ус хоёр хэсэг болон салж агаар мандал бий болсугай гэжээ.<sup>7</sup> Ингээд гүн усны нэг хэсэг нь ууршин агаар мандлын дээр үүл болон тогтож, нөгөө хэсэг нь агаар мандлынхаа доор үлдэв.<sup>8</sup> Ертөнцийн Эзэн үүл болон их усны хоорондох тэрхүү асар уудам орон зайг «тэнгэр» хэмээн нэрлэв. Ингээд шөнө болж улмаар өглөө эхлэн хоёрдахь өдөр өнгөрөв.<sup>6</sup>

<sup>9</sup>Гуравдахь өдрөө Ертөнцийн Эзэн,

— Тэнгэрийн доорхи тэрхүү хөлгүй их усны зарим нь хэсэг газарт хуралдан хуурай газар бий болсугай гэхэд тэр ёсоор нь газар бий боллоо.<sup>10</sup> Тэгээд Ертөнцийн Эзэн тэр хуурай газрыг «хөрс шороо», устай хэсгийг «далай» хэмээн нэрлээд энэ бүхэн үнэхээр сайхан болохыг харав.

<sup>11</sup>— Одоо газрын хөрс төрөл бүрийн өвс ногоо, жимсний бут, мод, үр тарианы ургамал ургуулах чадвартай болж, ургамал бүр өсч үржих үр үндэстэй болсугай хэмээн Ертөнцийн Эзэн хэлэхэд хэлсэн ёсоор нь болов.<sup>12</sup> Газрын хөрснөөс

---

а. «2 Коринф» 4-р бүлэг, 6-р зүйл.

б. «Пэтрийн 2-р захидал» 3-р бүлэг, 5-р зүйл.

төрөл бүрийн өвс ногоо, жимсний бут мод, үр тария ургажээ. Энэ бүхэн хир зэрэг сайхан болохыг Ертөнцийн Эзэн харав. <sup>13</sup>Ингээд шөнө болж улмаар өглөө эхлэн гуравдахь өдөр өнгөрөв.

<sup>14</sup>Дөрөвдэх өдөр нь Ертөнцийн Эзэн,

— Тэгвэл одоо өдөр, шөнийн ялгааг харуулан тэнгэрийг байнга гэрэлтүүлэх эрхэс хэрэгтэй. Үүгээр цаг хугацаа, улирал, он тооллыг тэмдэглэсүгэй. <sup>15</sup>Сансрын уудам дахь тэрхүү гэрэлт эрхэс газар дэлхийд гэрэл өгч байх болтугай гэхэд тэр ёсоор нь болов. <sup>16</sup>Ийнхүү Ертөнцийн Эзэн сансрын уудамд асартом хоёр гэрэлт эрхсийг бүтээж хурц гэрэлтэй нь өдөр, бүдэг гэрэлтэй нь шөнийн цагт гэрэлтэж байхаар болголоо. Мөн шөнийн

цагт гэрэлтэн харагдах оддын ертөнцийг бүтээв. <sup>17</sup>Ингээд дэлхийг гэрэлтүүлэх эрхсүүд тэнгэрт бий болов. <sup>18</sup>Тэнгэрийн тэрхүү эрхсүүдээр өдөр шөнийг ялгаж өдрийн тод гэрэл шөнийн харанхуйгаас ялгаатай болов. Ингээд бүтээсэн бүхэн нь хир зэрэг сайхан болохыг Ертөнцийн Эзэн харлаа. <sup>19</sup>Дараа нь шөнө болж улмаар өглөө эхлэн дөрөвдэх өдөр өнгөрөв.

<sup>20</sup>Тавдахь өдөр нь Ертөнцийн Эзэн,

— Далайн уснаас усанд сэлэгч амьтад бий болж агаарт нисэх жигүүртэн шувууд бий болог гэлээ. <sup>21</sup>Ингээд Ертөнцийн Эзэн далайн аврага биетнүүд болон төрөл бүрийн усны амьтад, агаарт нисэгч төрөл бүрийн жигүүртнүүдийг бий болгов. Энэ бүхэн хир зэрэг сайхан болсныг Ертөнцийн Эзэн

харлаа. <sup>22</sup>Тэгээд тэр бүгдийг өрөөн, өсөж үржих чадвартай болгон,

— Усны амьтад өсч үржин далайн усыг дүүргэж, жигүүртнүүд өсч үржин тоо томшгүй олон болтугай гэв. <sup>23</sup>Ингээд шөнө болж улмаар өглөө эхлэн тавдахь өдөр өнгөрлөө.

<sup>24</sup>Зургаадахь өдөр нь  
Ертөнцийн Эзэн,

— Газар дэлхийд төрөл төрлийн амьтад, хэвлээр явагчид, шавьж хорхой мөн түүнчлэн тэжээвэр амьтад бий болсугай гэв. Ийнхүү хэлсэн ёсоор нь болж.

<sup>25</sup>Ертөнцийн Эзэн төрөл төрлийн амьтад хэвлээр явагчид, шавьж хорхой мөн, түүнчлэн тэжээвэр амьтдыг бүтээв. Энэ бүхэн маш сайхан болсныг Ертөнцийн Эзэн харав.

<sup>26</sup>Тэгээд Ертөнцийн Эзэн,

— Одоо далайн амьтад, жигүүртэн шувууд зэрлэг болон тэжээмэл амьтад хөрст дэлхий болон түүнд амьдрагч бүх мөлхөгчдийг захирах хүнийг бид<sup>a</sup> өөртэйгөө адил төстэйгөөр бүтээх болно гэв.<sup>6</sup> <sup>27</sup>Ийнхүү Ертөнцийн Эзэн өөртэйгөө олон талаар адил төстэй эрэгтэй, эмэгтэй хүн гэгчийг бүтээв.<sup>8</sup>

<sup>28</sup>Тэгээд тэднийг өрөөхдөө:

— Үр удам чинь олширч, өнөр өтгөн болоод, газар сайгүй амьдарч, түүгээр ч барахгүй тэнгис далайн амьтад, тэнгэрт

---

а. Өндөр хүндэтгэлийг илэрхийлэхдээ Еврей хэлэнд олон тооны төлөөний үгээр ханддаг байв. Тиймээс «бид» гэдэг нь Ертөнцийн Эзэнийг ихэд хүндэтгэсэн санааг илэрхийлнэ. Харин Ертөнцийн Эзэн олон байдаг гэсэн үг биш юм.

б. «1 Коринф» 11-р бүлэг, 7-р зүйл.

в. «Матай» 19-р бүлэг, 4-р зүйл. «Маарх» 10-р бүлэг, 6-р зүйл.

нисэх жигүүртэн шувууд болон газар дээр амьдрагч бүх амьтныг захирч энэ дэлхийг эзэгнэсүгэй гэв.<sup>a</sup>

<sup>29</sup>Ертөнцийн Эзэн эрэгтэй, эмэгтэй хүнд хандан,

— Харагтун. Газар дэлхийн үр тарианы ургамал болон үр жимст бут мод бүрийг би та нарын хоол тэжээл болгон өглөө.

<sup>30</sup>Мөн төрөл бүрийн өвс, ногоон ургамлыг энэ дэлхийн бүх амьд биетэн, тэжээвэр болон зэрлэг амьтад, жигүүртэн шувуу, хэвлээр явагчдын идэх хоол болголоо гэхэд хэлсэн ёсоор нь болов.

<sup>31</sup>Ингээд Ертөнцийн Эзэн бүтээсэн бүхнээ хараад бүрэн төгс сайхан байлаа. Тийнхүү үдэш болж дараагийн өглөө эхлэн зургаадахь өдөр өнгөрөв.

2-р бүлэг. <sup>1</sup>Ертөнцийн Эзэн ийнхүү орчлон ертөнц болон амьтай амьгүй байгалийг бүтээж дуусав. <sup>2</sup>Ийнхүү долоодахь өдрөөс өмнө бүх ажлаа гүйцээсэн учраас дараагийн өдөр нь амарч, <sup>3</sup> амарсан тэр өдрөө тусгай өдөр болгохоор шийдэн өрөөлөө.<sup>b</sup>

а. Энэ ном 5-р бүлэг, 1,2-р зүйл.

б. Энэ нь бидний тооллоор бямба гариг. Учир нь, еврейн тоолол ёсоор долоо хоногийн эхний өдөр нь ням гаригаас эхэлдэг. «Еврейчүүдэд» 4-р бүлэг, 4,10-р зүйл.

в. «Чөлөөлөгдсөн нь» 20-р бүлэг, 11-р зүйл.

### Анхны эрэгтэй, эмэгтэй хүн

<sup>4</sup>Ертөнцийн Мөнх Эзэн орчлон ертөнцийг бүтээснээс хойш юу болсон тухай түүх эндээс эхэлнэ.

<sup>5</sup>Ертөнцийн Мөнх Эзэн энэ дэлхийг бүтээсний дараахан бут мод, ургамал ногоо хараахан ургаагүй байжээ. Тэр үед Ертөнцийн Мөнх Эзэн хур бороо оруулж эхлээгүй байснаас гадна тариа тарих хүн ч бий болоогүй байсан юм.

<sup>6</sup>Харин газрын гүний ус доороос нэвчин гарч ирж хөрсийг чийглэдэг байв.

<sup>7</sup>Тэгээд Ертөнцийн Мөнх Эзэн газар шорооны бичил бодисоор хүнийг бүтээж амь нас өгч хамар руу нь үлээхэд тэр хүн амь орлоо.<sup>3</sup>

<sup>8</sup>Дорно зүгт орших Ээдэн гэдэг газар Ертөнцийн Мөнх Эзэн цэцэрлэг бий болгоод бүтээсэн хүнээ тэнд авчирлаа.

<sup>9</sup>Ертөнцийн Мөнх Эзэн тэндхийн хөрс шорооноос янз бүрийн үзэмж төгөлдөр тансаг амттай жимсний мод ургуулав. Тэгээд цэцэрлэгийн дунд амьдрал өгөгч мод болон сайн мууг танин мэдүүлэх мод хэмээх хоёр модыг ургуулжээ.<sup>4</sup>

<sup>10</sup>Ээдэнд урсаж ордог ганцхан мөрний ус цэцэрлэгийг усалдаг байлаа. Ээдэнгээс гараад мөрөн гол дөрөв салаалан

<sup>11</sup>Пишон хэмээх эхний салаа нь Хавилаах гэдэг нутгаар урсан өнгөрдөг байв. <sup>12</sup>Хавилаах нутагт шижир алт, нэг янзын модноос гардаг анхилуун үнэртэй, «бэдөлөх» гэдэг тансаг давирхай, мөн танан судалт гартаам эрдэнэс байлаа.

<sup>13</sup>Мөрөн голын хоёрдахь салааг Гихун гэдэг бөгөөд энэ нь Хүш буюу Вавилон орноор урсаж байв.

<sup>14</sup>Гуравдахь салааг нь Тигр гэдэг бөгөөд энэ нь Ассири орны зүүн талаар урсдаг байлаа.

Дөрөвдэх салаа нь Евфрат гэдэг нэртэй байжээ.

---

а. «I Коринф» 15-р бүлэг, 45-р зүйл.

б. «Үзэгдэл» 2-р бүлэг, 7-р зүйл; 22-р бүлэг, 2,14-р зүйл.

<sup>15</sup>Ертөнцийн Мөнх Эзэн бүтээсэн анхны хүнээ Ээдэн цэцэрлэгт авчраад, цэцэрлэгийг арчлан харах үүрэг өгөв.

<sup>16</sup>Тэгээд Ертөнцийн Мөнх Эзэн хүнд хандан тушаахдаа:

— Чи эндхийн аль ч модноос дураараа жимс авч идэж болно. <sup>17</sup>Харин сайн мууг танин мэдүүлэх модноос жимс бүү авч ид. Хэрэв идвэл идсэн өдрөө үхэх болно шүү.

<sup>18</sup>Тэгээд:

— Ганцаараа байх нь хүнд таатай биш юм. Түүнд таарч тохирсон нэг хань бүтээж өгье хэмээн Ертөнцийн Мөнх Эзэн шийдлээ.

<sup>19</sup>Ертөнцийн Мөнх Эзэн газар шорооны бичил бодисоор төрөл төрлийн тэжээвэр болон зэрлэг амьтад, жигүүртэн шувуудыг бүтээж хүнд аваачин нэр өгүүлсэн учраас амьтан бүр өөр өөрийн гэсэн нэртэй болов. Бүтээсэн амьтанд нь хүн ямар нэр өгөхийг Ертөнцийн Мөнх Эзэн харж байлаа.<sup>5</sup>

<sup>20</sup>Хүн ийнхүү зэрлэг болон тэжээмэл амьтан, жигүүртэн шувуу бүрт нэр өгсөн боловч тэдгээрийн дотор өөрт нь таарах хань огт байсангүй.

<sup>21</sup>Иймээс Ертөнцийн Мөнх Эзэн өнөөх хүнийг таг унтуулаад нэг хавиргыг нь авч шархыг оргүй өдгээгээд <sup>22</sup>тэр хавирганд үндэслэн нэгэн эмэгтэй хүн бүтээж хүнд авчран үзүүлэхэд хүн түүнийг хараад:

<sup>23</sup>— За, энэ чинь харин надад таалагдаж байна. Миний яснаас бүтсэн яс, махнаас бүтсэн мах ажээ. Тийм учраас «эрэгтэй» надаас үүссэн энэ хүн «эмэгтэй» гэж нэрлэгдэг гэв.<sup>6</sup>

а. АН амьтныг захирах эрхийг хүн авсан болох нь үүнээс харагдана.

б. Эртний еврей хэлнээс үзвэл энэ үгний зөвхөн төгсгөл нь өөр сонсогддог. Үүнд: эрэгтэй хүнийг «иш», эмэгтэй хүнийг «ишишах» гэдэг байжээ.

<sup>24</sup>Ийнхүү эрэгтэй, эмэгтэй хоёр бие биедээ яг тохирдог учраас эрэгтэй хүн, эх эцгээсээ тусдаа гарч ханьтай болон хоёул нэгэн бие мэт нэгддэг учиртай.<sup>a</sup>

<sup>25</sup>Анхны тэр хүн, ханийнхаа хамт хувцасгүй, нүцгэн явдаг байсан боловч ичнэ гэдгийг тэд огт мэддэггүй байлаа.

### Хүн анх удаа Ертөнцийн Мөнх Эзэний тушаалыг зөрчсөн нь

3-р бүлэг. <sup>1</sup>Ертөнцийн Мөнх Эзэний бүтээсэн бүх амьтдын дотроос хамгийн их хорон санаатай, заль мэхтэй амьтан нь могой байв.<sup>b</sup> Могой эмэгтэй дээр очиж,

— Ертөнцийн Эзэн та нарыг ямар ч модноос жимс авч идэж болохгүй гэсэн нь үнэн үү? гэхэд эмэгтэй,

<sup>2</sup>— Бид энэ моднуудаас жимс авч идэж болно. <sup>3</sup>Харин Ертөнцийн Эзэн бидэнд «Цэцэрлэгийн төвд байгаа нэг л модноос жимс авч идэж болохгүй. Тэр ч байтугай гар хүрч болохгүй. Идвэл үхнэ» гэсэн гэхэд,

<sup>4</sup>— Тэр чинь ёстай худал! Та нар үхэхгүй ээ! <sup>5</sup>Хэрэв тэр жимсийг идвэл, хүний нүд гэнэт нээгдэх мэт болж, түүний адил сайн мууг ялгах чадвартай болно гэдгийг Ертөнцийн Эзэн мэдэж байгаа учраас тэгж хэлсэн гэж могой өгүүллээ.

<sup>6</sup>Эмэгтэй мод руу хараад жимс нь амттай сайхан санагдан хараа булааж, улмаар цэцэн цэлмэг болбол хичнээн сайхан бол гэсэн бодол орж ирэхэд тэрээр жимс авч идээд дараа нь нөхөртөө бас өгөхөд нөхөр нь идэв. <sup>7</sup>Тэр даруй өнөөх хоёрын нүд нээгдэх мэт болж өөрсдийнхөө нүцгэн байгааг мэдээд инжир модны<sup>b</sup> навчаар хормогч хийгээд бүсэлхийдээ зүүжээ.

---

a. «Матай» 19-р бүлэг, 5-р зүйл. «Маарх» 10-р бүлэг, 7,8-р зүйл. «1 Коринф» 6-р бүлэг, 16-р зүйл. «Эфэс» 5-р бүлэг, 31-р зүйл.

b. Энэ могой нь адгийн муу ёрын сүнсийг төлөөлжээ. «Үзэгдэл» 12-р бүлэг, 9-р зүйл; 20-р бүлэг, 2-р зүйл.

в. Шүүсэрхэг амттай жимстэй, дулаан орны мод.

<sup>8</sup>Үдшийн бүрий болоход Ертөнцийн Мөнх Эзэн Ээдэн цэцэрлэг дунд явааг эрэгтэй, эмэгтэй хоёр сонсоод моддын дунд орж түүнээс нуугдав. <sup>9</sup>Гэвч Ертөнцийн Мөнх Эзэн эрэгтэйг дуудан:

- Чи хaa байнаа? гэхэд эрэгтэй,
- <sup>10</sup>— Таны яваа чимээг сонсоод нүцгэн болохоороо айгаад танаас нуугдсан юмаа гэж хариулав.

<sup>11</sup>— Нүцгэн гэдгийг чинь чамд хэн хэлсэн бэ? Миний хориглосон тэр нэг модноос чи жимс авч идээ юу? гэж Ертөнцийн Мөнх Эзэн хэлэхэд <sup>12</sup>эрэгтэй хүн,

— Таны өгсөн тэр эмэгтэй л надад авчирч өгсөн учраас би идсэн гэж хариулав. <sup>13</sup>Ертөнцийн Мөнх Эзэн нөгөө эмэгтэйд хандан,

— Юу хийж байгаа чинь энэ вэ? гэхэд:

— Тэр могой л намайг мэхэлснээс боллоо гэж хариуллаа.<sup>a</sup>

### Шийтгэл

<sup>14</sup>Ертөнцийн Мөнх Эзэн могойг хараан:

---

<sup>a.</sup> «2 Коринф» 11-р бүлэг, 3-р зүйл. «1 Тимотод» 2-р бүлэг, 14-р зүйл.

— Ийм муу юм хийснийхээ төлөө чи бусад бүх мал амьтдын дотроос ганцаархнаа миний хараалыг хүртэнэ. Чи үргэлж элгээрээ мөлхөж, амаараа шороо үмхэж явах болно.<sup>15</sup> Энэ эмэгтэй болон та нарын хооронд өс хонзон бий болно. Түүний үр, чиний үр бие биедээ хорсох болно. Эмэгтэйн үр чиний толгойг хага цохих болно. Харин чи түүний удмын өсгийг гэмтээх болно гэлээ.<sup>a</sup>

<sup>16</sup> Ертөнцийн Мөнх Эзэн эмэгтэйд хандан:

— Ийм муу юм хийсний чинь төлөө чамайг би шийтгэнэ. Чи жирэмсэн болохдоо олон янзын зовиуртай болж үр хүүхдээ төрүүлэхдээ маш их өвдөж зовдог болно. Эр нөхрөө эзэмдэн захирахыг чи хичнээн хүсэвч тэр чинь чамайг захирдаг болно гэв.

<sup>17</sup> Ертөнцийн Мөнх Эзэн эрэгтэйд хандан:

— Чи эхнэрийнхээ үгийг дагаж «Хэзээ ч бүү ид» гэж миний хориглосон тэр модноос жимс идсэн учраас би газар шороог чинь хараана. Чи хоолоо олж идэхийн тулд үргэлж газар шороо малтан, хөлсөө урсган ажиллах хэрэгтэй болно.<sup>18</sup> Ийнхүү тариан талбайдаа чи хичнээн их зүтгэн ажиллавч хөрс шороонд чинь өргөс шивээтэй хогийн ургамал ургаж, заримдаа чамд хээрийн өвс идэхээс өөр аргагүй үе ирнэ.<sup>b</sup> <sup>19</sup> Ийнхүү чи хоолоо олохын тулд хүчээ шавхаж, хөлсөө урсгах болно. Үхэн үхтлээ, газар шороонд орон ортлоо чи ийм үйлээ үзсэн хэцүү амьдралыг туулна. Би чамайг газар шорооны бодисоор бүтээсэн. Чи шорооноос үүсэлтэй учраас эргээд шороо болох ёстой гэв.

<sup>20</sup> Тэр эмэгтэй бүх хүн төрөлхтний эх болох учраас нөхөр нь түүнд «Хаваах» гэдэг нэр өглөө.<sup>b</sup> Нөхрийг нь «Адаам» гэдэг байв.<sup>c</sup>

---

a. «Үзэгдэл» 12-р бүлэг, 17-р зүйл.

b. «Еврейчүүдэд» 6-р бүлэг, 8-р зүйл.

c. Хуучин еврей хэлний «Хаваах» гэдэг үг нь, монголоор «Амьдрал» гэсэн утгатай, грекээр «Эва» гэсэн үг.

### Ээдэн цэцэрлэгээс хөөгдсөн нь

<sup>21</sup>Ертөнцийн Мөнх Эзэн Адаам болон түүний эхнэрт амьтны арьсан хувцас хийгээд өмсүүлэв. <sup>22</sup>Ингээд,

— За одоо энэ хүмүүс бидний<sup>a</sup> адил сайн мууг таньж мэддэг болсон. Үүнээс гадна «амьдрал өгөх» модноос жимс авч идээд мөнх амьдарч болзошгүй <sup>23</sup>хэмээн болгоомжлоод, тэднийг Ээдэн цэцэрлэгээс хөөлөө.<sup>b</sup>

Ертөнцийн Мөнх Эзэн хүнийг газар шорооны бодисоор бүтээсэн учраас түүгээр газар шорооны ажил хийлгэх болов.

<sup>24</sup>Ертөнцийн Мөнх Эзэн хүнийг ийнхүү цэцэрлэгээс бүрмөсөн хөөн зайлуулаад амьдрал өгөх модонд хэнийг ч ойртуулахгүйн тулд цэцэрлэгийн зүүн талын замыг харж хамгаалах үүрэгтэй байнга эргэлдэн хөдөлж байдаг галт сэлэм барьсан ер бусын харуул тавилаа.

### ЭХЛЭЛ

© «Библийн Нэгдсэн Нийгэмлэг», 1994

Номын чимэглэлийн зургийг зураач Анни Валлоттон зурав.

© «Америкийн Библийн Нийгэмлэг», 1976

Хавтасны зургийг — © «»

Монголын Библийн Нийгэмлэг — Улаанбаатар — 49, ш/х 462